



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/40

Зуунмод

Шуурхай штабыг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 8 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн шуурхай штабыг байгуулж, штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга (Г.Сурмаа)-д, штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг хэлтэс, агентлагийн дарга, аймгийн гамшгаас хамгаалах албадын дарга, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг штабын Захиргаа, санхүүгийн багийн ахлагч (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 25 -ны өдрийн А/40- дүгээр
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: (Аймгийн Засаг даргын орлогч)

Орлогч дарга: (Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга)

Гишүүд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын дарга)

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

(Мал эмнэлгийн газрын дарга)

(Цэргийн штабын дарга)

(Цагдаагийн газрын дарга)

(Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

(Төрийн үйлчилгээ, хэвлэл мэдээллийн алба)

(Аюулт үзэгдэл, ослын нөхцөл үүссэн сумдын Онцгой комисс, холбогдох хэлтэс, агентлагийн дарга нар)

Нарийн бичгийн дарга: (Онцгой байдлын газрын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

оОо